**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 02 сарын 08 өдөр Дугаар А/03 Улаанбаатар хот

Баярын өдрүүдийн үеийн тусламж,
үйлчилгээг зохицуулах тухай

Монгол Улсын Эрүүл Мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйл, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4.1.1 дэх заалт, Нийслэлийн Эрүүл Мэндийн газрын 2023 оны А/223 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган ТУШААХ нь:

1. Сар шинийн баяр, нийтээр тэмдэглэх баяр, амралтын өдрүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, баярын арга хэмжээний үеийн яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангах зорилгоор баярын амралтын өдрүүдэд ажиллах хариуцлагатай жижүүрийн хуваарь, жижүүр болон дуудагдах сувилагч, ажилчдын хуваарийг хоёрдугаар хавсралтаар батлсугай.

2. Хариуцлагатай жижүүр болон ажилчдад ДААЛГАХ нь:

2.1. Сар шинийн баяр амралтын өдрүүдэд (2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 12-ний өдөр) өдрүүдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээг цаг алдалгүй түргэн шуурхай, стандартын дагуу үзүүлж ажиллахыг ажилчдад

2.2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний мэдээ, тайланг цахим программд цаг хугацаанд нь мэдээлж ажиллахыг Хүний нөөцийн ажилтан (Г.Гантуяа), статистикийн ажлын хавсран гүйцэтгэж байгаа (Б.Арвижих) нарт

2.3. Баярын амралтын өдрүүдэд эмч, эмнэлгийн ажилчид харилцаа холбооны бэлэн байдлыг хангаж, утсаа унтраахгүй байх, дуудлага аваагүй нөхцөлд даруй эргэж холбогдох, дүүргээс удаан хугацаагаар гарахгүй байх, зайлшгүй тохиолдолд байгууллагын удирдлагад мэдэгдэхийг бүх ажилчдад

2.4. Нийтээр тэмдэглэх баярын болон амралтын өдрүүдэд хүлээн авах,

яаралтай тусламжийн тасагт нэмэлтээр эмч, сувилагч, шаардлагатай ажилчдыг томилон ажиллуулж, ачааллыг зохицуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Хүний нөөцийг ажилтан /Г.Гантуяа/-д

2.5. Хүүхдийн амьсгалын замын өвчлөл, томуу томуу төст өвчин, асаргааны талаар зөвлөгөөг 7049103-утсаар 24 цагт тогтмол өгч ажиллахыг тухайн өдрийн жижүүр эмч, сувилагч нарт

2.6. Шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хувцас хэрэгсэл, оношлуурын нөөцийг бүрдүүлэх бэлэн байдлыг хангаж ажиллахыг эм найруулагч /Д.Дашдулам/-д

2.7. Түргэн тусламжийн үйлчилгээний бэлэн байдлыг хангах, яаралтай тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг эмч, сувилагч нар

2.8. Шатахуун тослох материалын нөөцийг бүрдүүлэх автомашины бэлэн байдлыг хангаж ажиллахыг жолооч нарт

2.9. Яаралтай үед иргэдийг хэвтүүлэн эмчлэх орны нөөцийг бэлэн байлгах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ шаардагдах иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэх, бэлэн байдлыг хангаж ажиллахыг эмч, сувилагч нар

2.10. Болзошгүй гамшиг, байгалийн аюулт үзэгдэл, хордлого, томоохон осол гэмтэл, тусламж, үйлчилгээ болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой ноцтой зөрчил гарсан тухай бүр байгууллагын болон газрын удирдлагад шуурхай мэдээлэх, шаардлагатай хариу арга хэмжээг цаг алдалгүй авахыг хариуцлагатай жижүүр болон жижүүр эмч нарт

2.11. Тусламж, үйлчилгээнд өвчтөний хоол, хүнсийг хүрэлцэх хэмжээгээр нөөцлөх, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллахыг нярав /Б.Энхцэцэг/-т

2.12. Баярын үеэр олон хоног амрахтай холбогдуулан байгууллагын болон тусламж үйлчилгээний хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангах, эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын сахилга хариуцлагыг өндөржүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч, ажилчдын ажил үүргийг хуваарийн дагуу бэлэн байдлыг хангаж ажиллахыг ажилчдад

2.13. Тушаалыг хэрэгжүүлж баяр, амралтын өдрүүдэд хариуцлагатай жижүүрээр ажилласан албан хаагчдыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу амралтыг биеэр эдлүүлэх, батлагдсан төсөвтөө багтаан илүү цагийг тооцон олгохыг Хүний нөөцийн ажилтан /Г.Гантуяа/, нягтлан бодогч /Б.Батжаргал/ нарт

2.14. Болзошгүй гамшиг, байгалийн аюулт үзэгдэл, хордлого, томоохон осол гэмтэл, тусламж, үйлчилгээ болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой ноцтой зөрчил гарсан тухай бүр эрүүл мэндийн газрын удирдлагад шуурхай мэдээлэх, шаардлагатай хариу арга хэмжээг цаг алдалгүй авах.

3. Хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй хоолны хордлого, хордлогот халдварт гарахаас урьдчилан сэргийлэх, илэрсэн алдаа зөрчлийг арилга арга хэмжээг зохион байгуулж тайланг (үр дүнг) удирдлагад мэдээлж ажиллахыг Чанарын менежер (Д.Дашдэлэг)-т үүрэг болгосугай.

4. Иргэдэд зориулсан нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааг хийх арга зүйг боловсруулан эрчимжүүлэн ажиллахыг Хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан /Г.Гантуяа/-д даалгасугай.

5. Баяр, амралтын өдрүүдэд хяналтаар болон мэдээ тайлан гаргаж ажилласан албан хаагчдын тайланг авч нэгтгэн удирдлагад танилцуулахыг Хүний нөөцийн ажилтан /Г.Гантуяа/, тайланг үндэслэн илүү цагийн хөлсийг бодож олгохыг Нягтлан бодогч /Б.Батжаргал/ тус тус үүрэг болгосугай.

6. Баяр наадмын өдрүүдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ болон хүний нөөцийн ажил үүргийн зохицуулалт, үйл ажиллагаатай холбоотой үүссэн нөхцөл байдлын талаар байгууллагын удирдлагад шуурхай танилцуулж тухай бүр нь шийдвэрлэж ажиллахыг их эмч (О.Номиндалай), Хүний нөөцийн ажилтан (Г.Гантуяа) нарт даалгасугай.

ДАРГА Х.ГАНБАТ

9920110134 СБТ-12044 1653202

Багахангай Эрүүл мэндийн төвийн даргын
2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн
А/03 тушаалын хавсралт

## ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН ХУВААРЬ

| № | Овог нэр | Албан тушаал | Хугацаа | Холбоо барих утас | Хяналт тавих хариуцлага жижүүр албан тушаал, утас |
|---|---|---|---|---|---|
| Жижүүр эмч нар | | | | | |
| 1 | Ч.Баасанноров | Их эмч | 2-р сарын 10 | 88031157 | Чанарын менежер Д.Дашдэлэг 99293255, Хүний нөөц дотоод хяналтын ажилтан Г.Гантуяа 88251080 |
| 3 | Б.Цэрэнчимэг | Мэдрэлийн эмч | 2-р сарын 11 | 99294917 | |
| 4 | О.Номиндалай | Их эмч | 2-р сарын 12 | 91030700 | |
| Дуудагдах эмч нар | | | | | |
| 1 | Б.Цэрэнчимэг | Мэдрэлийн эмч | 2-р сарын 10 | 99294917 | |
| 2 | О.Номиндалай | Их эмч | 2-р сарын 11 | 91030700 | |
| 3 | Г.Оюундулам | Дүрс оношлогооны эмч | 2-р сарын 12 | 99446054 | |

## БАЯРЫН ӨДРҮҮДЭД ГАРАХ ЭЭЛЖИЙН АЖИЛЧДЫН ХУВААРЬ

| Нэр | 2-р сарын 10 | 2-р сарын 11 | 2-р сарын 12 | 16 Утас |
|---|---|---|---|---|
| Сувилагч нар | | | | |
| Г.Болд | д | 24 | | 80105909 |
| М.Оюунтүлхүүр | 24 | | д | 85227338 |
| Х.Далайбаяр | | д | 24 | 99155748 |
| Асрагч нар | | | | |
| Л.Хишигдолгор | | 8-20 | 20-8 | 88822759 |
| Ариунсайхан | 20-8 | | | 90094790 |
| Д.Оюунсүрэн | 8-20 | 20-8 | | 80018826 |
| Б.Лхамсүрэн | | | 8-20 | 95725110 |
| Жолооч нар | | | | |
| Д.Амраа | ж | | ж | 99784313 |
| Э.Мөнхбат | | ж | | 99661374 |